



Дүүргийн анхан шатны 3 дугаар шүүхийн захиргаа болон үйлчилгээний албан хаагчидтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулан тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан баталгаажуулж гүйцэтгэлд хагас бүтэн жилээр үнэлэлт дүгнэлт өглөө.

Нийслэлийн шүүхээс ирүүлсэн ажилтнуудын хувийн хэрэг материалыг шинэчилж, шаардлагатай баримт сэлтийн бүрдлийг хангаж хувийн хэргийн баяжилтыг тухай бүрт хийлээ.

"Microsoft word" программд хүний нөөцийн мэдээллийн санг байршуулж захиргаа болон үйлчилгээний албан хаагчаар ажиллах хүний нөөцийн судалгааг бүрдүүлж, өөрчлөлт, хөдөлгөөнийг тогтмол хийж байна.

Шүүгчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулах, их хэмжээний өөрчлөлт орсон даруйд өөрчлөлт хийлгэж ШЕЗ-д хүргүүлж байгаагийн зэрэгцээ төрийн захиргааны жинхэнэ албан хаагчдын ХОМ-ыг журмын дагуу гаргуулан авч ажиллав.

Тайлангийн хугацаанд ДЭХАШ-ны шүүхэд Т.Эрдэнэтунгалаг, ДИХАШ-ны 3-дугаар шүүхэд Б.Байгалмаа, Тамгын газрын даргаар Б.Эрдэнэбаяр, Зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэнээр Х.Бадамжаргал, Шүүгчийн туслахаар П.Нансалмаа, Б.Жамбал, Б.Гантуяа, нарийн бичгийн даргаар Д.Анхбаяр, Б.Шинэхүү, мэдээлэл лавлагааны ажилтнаар Д.Энхзаяа нар шинээр томилогдлоо.

Шүүхийн хүний нөөцийн чиглэлээр нэгдсэн сан бий болгож бүртгэл хөтөлж байгаа бөгөөд одоогийн байдлаар 55 хүн захиргааны болон үйлчилгээний ажилтнаар ажилд орох өргөдлөө ирүүлж нөөцийн санд бүртгэгдсэн байна. Эдгээрээс 7 иргэн эвлэрүүлэн зуучлагч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, үйлчлэгч, няраваар ажилд орох хүсэлтээ ирүүлэн ажилд томилогдсон байна.

Тус шүүхийн захиргааны ажилтнуудаас 1 нарийн бичгийн дарга Баянзүрх дүүргийн шүүхэд шүүгчийн туслахаар, 2 шүүгчийн туслах өмгөөлөгчөөр, мөн 2 шүүгчийн туслах тухайн шүүхдээ шүүгчээр тус тус дэвшин ажиллаж байна.

Сургалтын чиглэлээр:

Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс зохион байгуулж буй дараах сургалтуудад оролцсон байна.

- ✓ Сургагч багшийн сургалт
- ✓ Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо
- ✓ Бэлгийн цөөнхийн эрх зүйн байдал
- ✓ Өлзийт ТГ-ын 2014-15 бүтэн жилийн ажлын дэлгэц
- ✓ Үйлчилгээний албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан баталгаажуулж гүйцэтгэлд хагас бүтэн жилээр үнэлэлт дүгнэлт өглөө
- ✓ Мөнгө угаах гэмт хэргийн үндсэн ойлголт
- ✓ Эвлэрүүлэн зуучлалын талаарх сургалт
 - ✓ Худалдааны эрх зүй



- ✓ Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийн системийн сургалт
- ✓ Авилгын индексийн 2013 оны судалгааны үр дүнгийн тайлан,улс төр хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн 2013 оны судалгааны тайлан /Авилгатай тэмцэх газар/
- ✓ Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд гарч буй тулгамдсан асуудал, цаашдын зорилт
 - ✓ Иргэний эрхзүйн сургалт /онлайн/
 - ✓ Байгууллагын ил тод байдлыг хангах арга зүй
 - ✓ Хэвлэл мэдээллийн ажилтнуудад зохион байгуулсан сургалт
 - ✓ Мэдээллийн аюулгүй байдал ба төрийн нууцын хамгаалалт сэдэвт сургалт
 - ✓ Орон тооны Эвлэрүүлэн зуучлагч нарын сургалт
 - ✓ Шинэ программын сургалт
 - ✓ Захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт,
 - ✓ Иргэн-1 программын сургалт
 - ✓ ИХХША-ны мэдээллийн системийн сургалт,
 - ✓ УТЕГ-аас зохион байгуулсан “Мэдээллийн аюулгүй байдал ба төрийн нууцын хамгаалалт”
 - ✓ Нийтийн эрх зүй
 - ✓ Иргэдийн төлөөлөгчийн асуудлаарх сургалтуудад ерөнхий шүүгч, шүүгчид , тамгын газрын дарга, зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн , шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга, мэдээлэл лавлагааны ажилтан, мэдээлэл технологийн мэргэжилтэн нар бүрэн хамрагдлаа.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс Тахарын Ерөнхий газраас зохион байгуулсан “Шүүгчийн аюулгүй байдлын зөвлөмж”, “Нэг бүрийн тусгай хэрэгсэл ба аминд үл хүрэх зэвсэг” сэдэвт сургалтанд шүүгч, шүүхийн ажилтнуудыг бүрэн хамруулсан ба Цагдаагийн хэлтэстэй хамтран “Шүүгчийн бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах” биечилсэн дадлага, сургалтыг зохион байгууллаа.

2014-2015 оны Тамгын газрын хичээлийн жилийн нээлтийн ажиллагааг зохион байгуулж, сургалтын төлөвлөгөө гарган шүүгч, ажилтан албан хаагчдад англи хэл, монгол бичиг, компьютерийн хэрэглээний программ, эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгуулж байна. Ажилтнуудыг сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангаж, сургалтанд оролцсон оролцоо, хандлага, олж авсан мэдлэгийг хүрээг харгалан үр дүнгийн гэрээний мэдлэг чадвараа дээшүүлэх зорилтын бүлэгт тусган дүгнэлээ.

Алба хаагчдын бие бялдар, хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих зорилгоор дүүргийн БТСХ-той хамтран ажиллах гэрээ байгуулан 7 хоног бүрийн Пүрэв гарагт 2 цаг спортын заланд чөлөөт цагийг өнгөрүүлж байна.



Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 24 төрлийн сургалтанд 267 шүүгч, ажилтан хамрагдсан байна.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гарч буй тогтоол, дүрэм журмыг тухай бүрт нь шүүгч ажилтнуудад хувиран өгч судлууллаа.

**Àóðàà: Àæëî í áàéðí û çéë àæëëääàà, ø ççðèéí çàðèðãààí û
yäèðäëääû í ì áí àæì áí ò èéã òýðýãæçéëõ чиглэлээр.**

Үйл ажиллагаандаа Шүүхийн тухай багц хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөн хэрэгжүүлж ажилласан ба Тамгын газрын даргын 99 тушаал гарснаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 48, хүний нөөцтэй холбоотой 20, хөрөнгө мөнгө захиран зарцуулахтай холбоотой 31 тушаал гарсан байна.

Дүүргийн Эрүүгийн болон Иргэний хэргийн шүүхийн ажлын байрны хүрэлцээ, ажиллах орчин нөхцөл шаардлага хангахгүй байгаа байдлын талаар дүүргийн Засаг даргад танилцуулснаар 2014 оны 1-р сараас Татварын хэлтсийн сургалтын танхимыг, 2014 оны 08-дугаар сараас Худалдан авах ажиллагааны байрыг өөрийн мэдэлд шилжүүлэн түрээсэлж, зохих засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсний үндсэн дээр үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоог бүрдүүллээ.

Шүүн таслах ажиллагааны мэдээ, тайланг улирал тутам гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөл рүү тогтмол хүргүүлж, өөрийн шүүхийн сайтад байршуулж хэвшсэн.

Төрийн захиргааны албан хаагчийн болон Шүүхийн ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, хяналт тавьж мөрдүүлэх чиг үүргийн хүрээнд Тамгын газрын дотоод журмыг шинэчлэн баталж, байгууллагын Ёс зүйн хороог байгуулж, ШЕЗ өөс баталсан “Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн хорооны ажиллах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Шүүхийн ёс зүйн хорооны даргаар Тамгын газрын дарга Б.Эрдэнэбаяр, гишүүдээр шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Х.Бадамжаргал, ерөнхий шүүгчийн туслах Б.Мөнх-Учрал нар сонгогдон ажиллаж байна.

Шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар дагнан ажиллуулж эхэлснээр ажлын үр дүнд сайнаар нөлөөлж байна.

Төрийн захиргааны ажилтнуудыг сар бүрээр ажлыг төлөвлүүлэн биелэлтийг гаргуулан гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч хэвшлээ.Шинээр томилогдох ажилтнуудыг журмын дагуу ШЕЗ-ийн дэргэдэх ТАСЗ, АТГ болон ТЕГ-аас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн томилж байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах ажлын хүрээнд шүүхүүдийн иргэдийг хүлээн авах хуваарийг гарган баталж мэдээллийн самбарт байрлуулсан. Одоогоор Дүүргийн анхан шатны 3 дугаар шүүхийн үйл ажиллагааны талаар иргэд, байгууллагаас гаргасан гомдол санал, хүсэлт ирээгүй байна. Иргэнээс Шүүхийн захиргааны ажилтантай холбоотой нэг



- Мөн шүүхийн архивт хадгалагдаж байгаа 1980-2013 оны бүх хэрэг, материалыг цахимжуулах ажлыг хийж дуусгасан.
- Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу архивт чийг дулаан хэмжигч байршуулж, цэвэрлэгээ үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хийж хэвшсэн.

Өнөөдрийн байдлаар тус шүүхийн архивт тооллогоор 2002 оноос хойших байнга хадгалагдах иргэний хэрэг 217 нэгж, түр хадгалах иргэний хэрэг 7380 нэгж, шүүхийн байнга хадгалах эрхийн акт 1154 нэгж, түр хадгалах эрхийн акт 960 нэгж, Тамгын даргын байнга хадгалах 64 нэгж, түр хадгалагдах 122 нэгж, эрүүгийн 95 буюу захиргааны 1022 нэгж, хянан магадлангийн 198 нэгж нийт 11212 нэгж материал хадгалагдаж байна.

Тамгын газарт 427 албан бичиг ирж 245 албан бичиг гадагш явсан ба хугацаатай албан бичгийн хариуг хуульд заасан хугацаанд хүргүүлж ажиллалаа.

Тав: Мэдээллийн технологийн чиглэлээр:

“Шүүхийн мэдээллийн технологийн үйл ажиллагааны нийтлэг журам”, “Серверийн өрөө, түүнийг ашиглах журам”, “Шүүхийн хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулах, архивлах журам” –ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа чанд мөрдөн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэрийн цахим санд тухайн шүүхийн шийдвэр, шийтгэх тогтоол, шийдвэрлэсэн хэргийн тойм, шүүх хуралдааны товыг зохих журмын дагуу байршуулж, хариуцсан ажилтнууд шүүхийн цахим мэдээллийг тогтмол баяжуулан ажиллаж байна.

Шүүхийн компьютер, хувилагч, хэвлэгч, хяналтын камер болон бусад тоног төхөөрөмж, дотоод болон интернэтийн сүлжээний хэвийн, тасралтгүй ажиллагааны бүрэн хангаж техник хангамжийн бүртгэлийг хөтлөн ажиллаж байна.

2014 онд иргэн-1 програмын гурван удаагийн шинэчлэлт хийгдсэн ба “Иргэн-1 програмыг” “Иргэн-2014” нэгдсэн системд шилжүүлж байгаатай холбогдуулан иргэн-1 програмын баазыг 2014 оны 07 дугаар сар 22 нд ШЕЗ-ын серверт хуулж, 2014 оны 08 дугаар сарын 1-ний өдөр ашиглахад бэлэн болгосон.

Judge2005 програмын баазыг 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдөр 2013 оны баазыг хуулж 2014 оны баазыг үүсгэсэн. Иргэдэд хэрэг болон нэхэмжлэлийн загвар, хохирогчийн эрх үүрэг, нэхэмжлэгчийн эрх үүрэг гэх мэт мэдээллийг хангах зорилгоор baganuur_shuukh.pro –програмийг хийж ашиглаж байгаа ба шинэчлэлийг цаг тухай бүрт нь хийж байна.

Шүүхийн шинэтгэлтэй холбогдуулан эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүх болон иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн веб сайтыг шинээр



хийж ашиглаж байна. Judge2005 программын 2014- оны бүтэн жилийн data баазыг CD-нд буулгаж авах бэлтгэл хийгдсэн.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах” төслийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн сервер, сүлжээний тоног төхөөрөмжийг хүлээн авч, “Нээлттэй шүүх” танхим шинээр байгуулан бүх тоног төхөөрөмжийг суурилуулан ашиглаж байна. Үүний үр дүнд шүүх хуралдааны явцыг ил тод харуулах, иргэд хүссэн цагтаа шүүх хуралдааны явцын талаар мэдээлэл авах боломжтой болж байгаа юм. Байгууллагын сервер болон компьютерт байгаа Judge2005 программын data баазыг harddisk болон CD-нд горимын дагуу хуулбарлан авч архивт шилжүүлэхэд бэлтгэв.

Мэдээллийг тодорхой хугацаанд файлаар архивлах зорилгоор server компьютерт байгаа нийт файлийг HDD дискэнд буулган цахим архив үүсгэн ажиллаж байна.

Шүүхийн мэдээлэл технологийн үйл ажиллагааг гадны нөлөөнөөс хамгаалах зорилгоор WIFI router ашиглахгүй мөн IP address search суулгаж сүлжээнд гаднаас ямар нэгэн компьютер нэвтэрч буйг шалгаж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Шүүх хуралдааны 540 дүрс бичлэгийг HDD хуулж зохих журмын дагуу архивлаж байна.

Архивын баримт материалын хадгалалтын хугацааг уртасгах, цаг үеийн өнөөгийн шаардлагыг нийцүүлэх зорилгоор нэгжүүдийг цахимжуулах ажлыг эхлүүлэн амжилттай хийж дуусгасан ба ашиглалтанд байсан дискний багтаамж хүрэлцэхгүй байснаас өндөр үзүүлэлтэй диск авч архивласан.

Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүх болон иргэний хэргийн анхан шатны 3 дугаар Шүүх, Тамгын газрын нэгдсэн веб сайтыг хэрэглэхэд хялбаршуулан шинээр хийж ашиглаж байгаа ба цаг үеийн мэдээ мэдээлэл, шүүх хуралдааны зар, шийдвэр, тогтоолыг өгөгдөл баазд оруулаа.

Эрүү, Иргэний шүүх хуралдааны танхимд дуу, дүрс бичиж архивлах төхөөрөмж суурилуулан самбар, проектор байрлуулж яллах өмгөөлөх талуудын илтгэл, шүүх хуралдааны тэмдэглэл зэргийг оролцогч болон танхимд байгаа иргэдэд ил тод нээлттэй байх бололцоог хангалаа. Мөн шүүх хуралдаанд насанд хүрээгүй этгээдийг оролцуулахдаа хүүхдийн өрөөтэй танхимаас видео хэлбэрээр харьцах, яллах өмгөөлөх талууд байр сууриа илэрхийлэхдээ проектер ашиглан тайлбарлах, CD-нд буулгасан бичлэг бүхий нотлох баримтыг үзэх зэрэгт проектын дэлгэц ашиглах техникийн дэвшлийг бүрдүүлсэн.

Зургаа: Шүүхийн судалгаа, мэдээлэл болон

хэвлэл мэдээллийн чиглэлээр



Орон нутгийн Сүлжээ-3, BBS телевиз, Багануурын амьдрал сонинтой 1 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ байгуулан Сүлжээ-3 телевизэд 12 , BBS телевизэд 13 мэдээ, сурталчилгааны шторк өдөр бүр, Багануурын амьдрал сонинд 5 мэдээ, мэдээллийг өгч олон нийтийн хүртээл болгон, шүүхийн үйл ажиллагаа, хараат бус байдлыг хангахад анхааран ажилласан байна.

Шүүхийн шийдвэр, тогтоол, шүүх хуралдааны зарыг www.shuukh.mn сайтад тогтмол байршуулан иргэд, олон нийтийг шүүн таслах ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллээр ханган ажилласан.

www.baganuurshuukh.mn сайтад дүүргийн анхан шатны 3-р шүүхийн үйл ажиллагаа, Тамгын газраас зохион байгуулан хийсэн ажлын талаарх өдөр тутмын мэдээ мэдээлэл, шүүх хуралдааны тойм, шүүх хуралдааны зарыг тогтмол байршуулан иргэдийг шүүхтэй холбоотой мэдээллээр ханган ажилласан байна. Тайлангийн хугацаанд цаг үеийн 53 мэдээ мэдээлэл, иргэний шүүх хуралдааны тов 236, тойм 150, шийдвэр 507, эрүүгийн шүүх хуралдааны тов 216, тойм 216, шийтгэх тогтоол 102-ыг байршуулсан байна.

Шүүхийн үйл ажиллагаа болон холбогдон гарах бусад асуудлаар олон нийтийн саналыг санал хүсэлтийн хайрцгаар болон baganuur_d@shuukh.mn хаягаар тогтмол хүлээн авч, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хангахад анхааран ажилласан.

Дүүргийн "Гүн галуутай", "Боловсрол" цогцолбор сургуулиудын 10 дугаар ангийн 45 сурагчийг ДЭИХАШ-ны 3 дугаар шүүхийн үйл ажиллагаа болон шүүх хуралдааны танхимтай танилцуулснаас гадна "Нээлттэй шүүх" арга хэмжээний хүрээнд шүүн таслах үйл ажиллагааг нээлттэй танилцууллаа.

ШЕЗ-ийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн 2014 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан орон нутгийн шүүхүүдийн үйл ажиллагааг сурталчлах, ил тод нээлттэй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд орон нутаг дахь шүүхийн үйл ажиллагааг танилцуулах, бодит мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор төвийн хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, зураглаачид тус шүүхийн үйл ажиллагаатай танилцлаа.

Өгөгдөл Ажлын үр дүнд нь мэдээлэл өгөгдөл хуулиудын дэлгэцэд өгөгдөл цагаан дэвсгэрийн Ойлголт мэдээлэл үндсэн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай танилцлаа.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс гаргасан богино хэмжээний видео сурталчилгаа <http://www.baganuurshuukh.mn/aya> сайтыг нээлттэй шүүх танхимаар дамжуулан өгөгдөл мэдээлэл үйл ажиллагааг олон нийтэд тогтмол танилцуулж мэдээ мэдээллийг тухай бүрд байршуулж шүүхийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилж байна.



Шүүхийн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдаар нүүдэллэн ажиллаж шүүхийн багц хууль болон шүүхэд хийгдэж байгаа шинэчлэлийн талаар сумдын иргэд ямар санал гаргаж байгаа, тухайн шүүхээс мэдээлэл авах боломж нь хэрхэн хангагдаж байгаа болон иргэдийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, нэхэмжлэл, өргөдөл, гомдол хүлээн авах, шүүхийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хууль сурталчлах ажлуудыг зохион байгуулсан.

“Багануурын амьдрал” сонинд шүүгч, тамгын дарга, шүүгчийн туслахууд мэдээлэл нийтлүүлсэн байна.

Мөн харьяалсан сумдын иргэдээс малчдын зөвлөгөөний үеэр санал асуулга авч үйл ажиллагаандаа дүгнэлт хийж цаашид хэрхэн ажиллах тухай төлөвлөж байна.

Долоо: Төсөв санхүү, хангамжийн менежментийн бۆдүүй ä

2014 оны батлагдсан төсвийг хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулж, тайлан баланс, холбогдох судалгааг хугацаанд нь гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж байна.

2014 оны 11-р сарын байдлаар батлагдсан 564.001.470 төгрөгийн төсвийн хүрээнд 499.902.628 төгрөгийг зарцуулж 64.098.842 төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. 2014 оны 11-р сарын байдлаар батлагдсан 564.001.470 төгрөгийн төсвийн хүрээнд 499.902.628 төгрөгийг зарцуулж 64.098.842 төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Шүүхийн шүүгч, ажилтнуудын “Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр”-т хууль тогтоомжийн дагуу бичилт хийх, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд туслах зорилгоор Хаан банкттай цалин, бизнес, лизингийн зээлийн гэрээ байгуулан 6 сараас 2 жил хүртэл хугацаатай зээл олгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Шүүхийн байрны болон түрээсийн байрны түрээс, ашиглалтын болон холбоо, дулаан, цахилгаан, цэвэр бохир ус, автогражын халаалтын гэрээг холбогдох газруудтай байгуулж хугацаанд нь дүгнэж, төлбөр тооцоог хийж өглөг, авлагагүй ажиллахад анхаарч ажиллав.

ШЕЗ-өөс шүүхүүдийн нүүдэллэн ажиллах, шүүхүүдийн үйл ажиллагааг хурдан шуурхай болгох, иргэдэд хүрч ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс олгосон Toyota Landcruiser Prado 150 маркын автомашиныг хүлээн авч балансад бүртгэн ашиглаж эхэллээ. Шуудан харилцаа холбооны зардлыг хэмнэх үүднээс Эрүү, Иргэний хэргийн шүүхийн байранд сүлжээндээ үнэгүй ярих эрх бүхий Mobicom, Unitel, Skytel-н 6 ширхэг утсыг тус тус байрлуулан шүүхийн шүүгч, ажилтнууд үйл ажиллагаандаа ашиглаж байна.



Шүүгч, шүүхийн захиргаа, үйлчилгээний ажилтнуудыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

-Шинээр томилогдсон шүүгчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээ

-“Эрүүл агаар-эм” явган аялал

-2014-2015-оны хичээлийн жилийн нээлтийн арга хэмжээ

-Аймаг орон нутгийн шүүхүүдийн туршлага судлах зэрэг нийтийг хамарсан ажил арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Шүүхийн нийт шүүгч ажилтнуудыг эрүүл аж төрөх, зөв дадал хэвшилд суралцуулах, эзэмшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажлын онцлогоос хамааралтай хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд өдөр бүрийн 11 цагт тогтмол дасгал хөдөлгөөн хийж эрүүл мэндийн нэгдэлтэй гэрээ байгуулан тодорхой сэдэвүүдээр сургалт авч шүүгч, ажилтнуудыг бүрэн хамруулж байна.

Төрийн захиргаа болон үйлчилгээний 16 ажилчны ар гэрт буцалтгүй тусламж, гэр хороололд амьдардаг 10 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт олгож, хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр байгууллагынхаа ажилчин албан хаагчдын хүүхдүүдэд гарын бэлэг гардууллаа. Эдгээрт 5.4 сая төгрөгийг зарцуулсан ба 3 шүүгчийг ШЕЗ-ийн орон байрны дэмжлэгт хамруулж, сар шинэ, ахмадын баяраар давхардсан тоогоор 4 өндөр настанд хүндэтгэл үзүүллээ. Шүүхийн үйлчлэгч, бичиг хүргэгч нарыг ажлын хувцсаар хангаж ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахиж байна.

ШЕЗ -өөс зохион байгуулсан “Эрүүл, ногоон орчин” сэдэвт аяны хүрээнд захиргааны болон үйлчилгээний ажилчдын дунд аяныг зохион байгуулж удирдамжийн дагуу хугацаанд нь дүгнэж байр эзлүүлээ.

Хүүхдийн болон залуучуудын зөвлөл нь Иргэний болон Эрүүгийн шүүхийн, Тамгын газрын шүүгч, ажилтан албан хаагчдийн хүүхдүүдийн дунд “ Гэрэлт ирээдүй” бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулсан.

Шүүхийн хүүхдийн өрөөг тохижуулан хүүхдийг хүлээлгэх хугацаандаа ном уншуулах, тоглоом тоглуулах, телевизор үзүүлэх зэрэг үйлчилгээгээр хангаж хүүхдийн эрхийг хангах асуудлыг боловсронгуй болгож байна.

Хуульч эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулсан боулингийн тэмцээнд тэргүүн байр, Багануур дүүргийн Засаг даргын тамгын газраас төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээний эрэгтэй төрөлд, Санхүүгийн ажилтнууд дүүргийн санхүүчдийн тэмцээний Дартс, боулингийн төрөлд тус бүр 1-р байр эзэлж алтан медалиар шагнууллаа.

Дүүргийн “Залуу гэр бүлийг дэмжих” жилийн ажлын хүрээнд зохиогдсон уралдаанд Шүүхийн Залуучуудын зөвлөлөөс оролцож “Дэд” байр эзэлж, өргөмжлөл мөнгөн шагнал, байгууллагын түүх бичих уралдаанд оролцож шагналт байрт шалгарлаа.



Шүүхийн эзэмшлийн автомашинуудыг техникийн үзлэг оношлогоонд цаг хугацаанд нь оруулж татварыг төлсөн бөгөөд автомашин ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Иргэддээ ээлтэй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, гэр хорооллыг тохилог, амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа “Жишиг хашаа, жишиг гудамж, жишиг хороолол” төсөлд нийт ажилтнуудаа хамруулж дүүргийн Өмч газрын харилцааны албанаас газрын батламж гардаж авсан ба Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт 20 айлын зуслангийн газар эзэмшихээр боллоо.

Хүйтний улиралд ажилчдад халуун аарц, шүүх хуралдааны дундуур хэргийн оролцогч нарт цай, кофе, халуун усаар үйлчлэх зэрэг ажлыг тогтмол хийж байна. Шүүхийн өндөр настан Ч.Сүрэнжавыг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор шагнуулахаар тодорхойлж шагнуулсан байна.

Дүүргийн анхан шатны 3 дугаар шүүхээс санаачлан Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа нийт шүүхийн байрны байрлалыг газрын зураг дээр харагдах байдлаар хэвлэн гаргаж ашиглаж байна.

Дүүргийн Онцгой байдлын албаны ажилтан, албан хаагчдад учирсан уй гашууг хуваалцан нас барсан албан хаагчдын гэр бүлийнхэнд шүүгч, ажилчдын нэг өдрийн цалин болох 400.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгож, залуучуудын зөвлөлөөс зохион байгуулсан сайн үйлсийн аяны хүрээнд дүүргийн 1 дүгээр хорооны амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 1 өрхийг сонгон авч 200.000 төгрөгний нүүрс, ахуйн хэрэгцээний бараа материалын тусламж үзүүлсэн байна.

Ажлын 7 хоног бүрийн даваа гарагт шуурхай зөвлөгөөн хийж Тамгын газрын ажлын мэдээллийг танилцуулж, шүүгч ажилтнуудын гаргасан ажил үүрэгтэй холбоотой санал санаачлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллав.

ÄÄÄÄ

Б.ЭРДЭНЭБЯАР.